

Баримт бичиг

боловсруулах, шинэ

баримт бичиг хэрэгжүүлэх



Prof. Dr. Cees Th. SMIT SIBINGA

IQM Consulting, Univ. of Groningen, NL

Агуулга

- Баримт бичиг төлөвлөх, боловсруулах
- Баримт бичиг хянах
- Баримт бичиг баталгаажуулах
- Баримт бичгийг хэрэглэх

Зарчим

Юу хийхийг бичиж баримтжуулна

Бичиж баримтжуулсан үйлдэл, үйл ажиллагааг л хийнэ

Бичиж, баримтжуулалт үйлдээгүй бол юу ч хийсэнд тооцохгүй

Тодорхойлолт

Баримтжуулалт


- Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой ажилбар, аргачлал, заавар, бүртгэл, чанарын хяналтын аргачлал, шинжилгээний үр дүнгийн бүртгэл зэрэг бүхий л бичигдсэн зүйлс

Баримтжуулалт

Баримт бичиг дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- Тохирсон бөгөөд байнга шинэчилж байх
- Тодорхой байх
- Товчхон байх
- Баталгаажуулдаг байх
- Дагаж мөрддөг байх

САЗ төлөвлөх зураглал (1)



САЗ ТӨЛӨВЛӨХ зураглал(2)

Хувьсах хэмжигдэхүүнүүд болон бэрхшээл тохиолдсон үед хэрхэн шийдвэрлэх шаардлагыг тогтоох



Баримт бичиг боловсруулах

- Бэлтгэл ажил
 - Баримт бичгийн зорилтыг ойлгох
 - Хэрэглэх үгс, нэр томъёонуудыг ойлгох
 - Шаардлагатай тоног төхөөрөмж, туслах материал, баримтуудыг ТОГТООХ

САЗ-ыг бичихэд баримтлах, баримтлахгүй зүйлс (1)

Баримтлах зүйлс:

- Эхэлж цэгцлээд дараа нь өгүүлбэр болгон бич
- Уг САЗ-ыг уншигч нь хэн байх вэ, зорилт нь юу вэ гэдгийг мэд
- Богино, төгс утгатай өгүүлбэр ашиглан догол мөргарган бич
- Нэг өгүүлбэрт зөвхөн нэг утга санааг тусга
- Энгийн үгээр товч тодорхой бич
- Бүрэн ойлгуулахын тулд зураг чимэглэл ашигла
- Хүмүүсийн мэдэхгүй нэр томъёо, тэмдэгүүдийг тайлбарла

САЗ-ыг бичихэд баримтлах, баримтлахгүй зүйлс (2)

Баримтлах зүйлс:

- Зөв бичгийн дүрэм, цэг таслал, том үсгээр эхэлж бичих үгс зэргийг анхаар
- Догол мөр болгонд нэг утга санааг илэрхийл
- Заавар буюу аргачлалыг тасралтгүй үргэлжлүүлж бич
- Ажилбарын хэлхээсийг дуусгах

САЗ-ЫГ бичихэд баримтлах, баримтлахгүй зүйлс(3)

Зайлсхийх зүйлс:

- Урт, ойлгомжгүй өгүүлбэр бичих
- Хоёрдмол утгатай санаа илэрхийлэх
- Бүдүүлэг болон ярианы хэллэг ашиглах
- Дайвар үгс, ач холбогдолгүй байц гишүүнийг хэрэглэх (Жишээ нь: чухал ач холбогдолтой, зохих, тохирох гэх мэт)
- Хэт олон үг өгүүлбэр хэрэглэх

•
•
•

САЗ-ыг бичихэд баримтлах, баримтлахгүй зүйлс(4)

- Чухал үгсийг орхих
- Тодорхой мэргэжлийн этгээд үг хэллэгийг ашиглах

САЗ-ЫН ТӨСЛИЙГ ХЯНАН ЗАСВАРЛАХ БА БАТАЛГААЖУУЛАХ

- Дор дурьдсан хүмүүс САЗ-ын төслийг хянан үзэж, санал зөвлөгөө өгөх юмуу өөрчилж бичих ёстой. Үүнд:
 - Энэ ажлыг гүйцэтгэх хүн
 - Энэ САЗ ажилд нь шууд ба шууд бус нөлөөлөх тасаг нэгж буюу хүмүүс
- Гэхдээ хэт олон хүний саналыг авна гэвэл маш олон санал шүүмжлэл гарч, уг аргачлалыг практикт нэвтрүүлэх үйл ажиллагааг удаашруулж болзошгүй

•
• Тухайн САЗ-ыг дагаж мөрдөхөд
оролцдог хүмүүсээр хянаж, засуулах

- Уг ажлыг хийдэг хүмүүсийн туршлагыг ашиглах
- Ингэснээр энэ САЗ-ыг одоо дагаж мөрдөх шаардлагатай болж байгаа ажилчдын дэмлэг туслалцааг авах боломж нэмэгдэнэ
- Хянах үйл ажиллагаа
 - САЗ-ын төсөл хэр оновчтой, тодорхой, ач холбогдолтойг шалгана
 - Уг аргачлалыг мөрдөх ажиллах ажилчин болоод тухайн тасгийн дарга хоёулаа хамт шалгалтыг хийнэ

САЗ-ЫН ЭЦСИЙН БАТЛАГААЖИЛТ

- Тухайн САЗ-ыг баримтласны эцсийн үр дүн нь анх төлөвлөж байсантай тохирч байгааг харуулна
- Баталгаажуулахад хүлээх үүрэг:
 - Чанарын менежер нь тасгийн эрхлэгч нарыг удирдан баталгаажуулах төлөвлөгөөг боловсруулна
- Баталгаажуулалтын явцад дараах асуултуудыг тавих хэрэгтэй. Үүнд:
 - Бүх үе шат багтсан байна уу?
 - Эцсийн үр дүн нь ижил байна уу?

Баталгаажуулалтын протокол

- Баталвал зохих шалгуур үзүүлэлтүүд
- Хэрэглэх арга
- Тухайн ажилбарыг гүйцэтгээд гарсан үр дүнг бичиж мэдээлэх
- Үр дүнг хянан үзэх
- Тухайн САЗ –ыг хүлээн зөвшөөрөх

Баримт бичгийг ашиглах

- Ажилбарыг гүйцэтгэхэд мөрдөх
- Тухайн ажлыг чанартай гүйцэтгэхэд тулгуурласныг батлан харуулах
- Сургалт
 - САЗ нэг бүрээр сургалт зохион байгуулах
 - Сургалт хийсэн тухай протоколын үндсэн материал болох

Гол ойлголт (1)

- Баримт бичиг нь чанарын тогтолцооны чухал хэсэг
- Баримтжуулалт нь үйл ажиллагаа, ажилбар тогтмол, зөв явагдсаныг батална
- Баримтжуулалт нь мөшгөн тогтоох боломжтой болгоно
- Сайн баримтжуулалт нь ажилтныг сургахад гарын авлага, материал, болно.